



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/06/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn
Аудитор: Д.Мөнхтулга
Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.03.25 № 1/125
танай 2024.03.04 ны № 1/133 -Т

ЖАРГАЛАНТ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН
ЗАХИРАГЧ Ц.ЦОГТБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 4 төсөвт байгууллага, 2 тусгай сан, сумын ерөнхий боловсролын сургуулиуд 7, 16-н цэцэрлэгүүд зэрэг байгууллагуудын тогтмол зардлыг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн байна.

Жаргалант сумын 2023 оны төсвийн орлогыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 7/10/05 дугаар тогтоолоор татвар, татварын бус орлогыг 9,439,300.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 10,628,573.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 1,189,272.5 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын үр дүнд сумын хөрөнгө 2,127.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны 4/12/02 тоот тогтоолоор "сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2023 оны хэрэгжилтийг 86.4 хувь буюу "хангалттай" гэж дүгнэжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан
(төгрөгөөр)

(мянган)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,465,307.6	5,742,050.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	504,463.80	2,802,778.60
33	АВЛАГА	1,061,857.40	1,054,357.00
34	УРЬДЧИЛГАА	707,802.80	1,632,531.60
35	БАРАА МАТЕРИАЛ	191,183.60	252,383.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,963,396.80	18,790,186.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,963,396.80	18,790,186.00
39200	Биет хөрөнгө	18,474,330.60	18,267,742.60
39300	Биет бус хөрөнгө	489,066.20	522,443.40
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	21,428,704.40	24,532,236.60
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	89,637.20	86,380.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89,637.20	86,380.70
41300	Өглөг	89,637.20	86,380.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	21,339,067.20	24,445,855.90
51	Засгийн газрын хувь оролцоо	21,339,067.20	24,445,855.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	11,107,384.20	11,107,384.20
51200	Хуримтлагдсан үр дүн	7,549,845.60	10,656,715.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,681,837.40	2,681,756.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	21,428,704.40	24,532,236.60

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,324,127.50	19,349,535.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,622,255.40	11,261,514.00
110	Орлогын албан татвар	7,949,397.60	10,401,597.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,949,397.60	10,925,241.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-523,643.50
113	Хөрөнгийн албан татвар	245,764.10	331,229.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	427,093.80	528,686.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,547,649.00	3,187,825.10
120	Нийтлэг татварын бус орлого	2,547,649.00	3,187,825.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,154,223.00	4,900,196.10

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	18,809,905.00	16,267,864.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,809,905.00	15,439,626.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,739,907.60	12,243,537.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,403,568.60	1,119,269.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,896.50	139,201.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,028,526.90	134,541.30
2104	Хангамж, бараа материалын зардал	1,397,914.30	1,822,178.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,058.20	1,590.60
2107	Томилолт, зочны зардал	3,331.80	6,608.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	745,473.20	5,695,311.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,917,138.20	3,324,836.60
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	85,934.40	76,666.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,984,063.00	3,119,422.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	828,237.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	514,222.50	3,081,671.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	41,074,947.30	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-40,560,724.80	3,081,671.10

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	17,098,639.10	16,386,085.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,622,255.40	11,261,514.00
110	Орлогын албан татвар	7,949,397.60	10,401,597.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	7,949,397.60	10,925,241.30
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-523,643.50
113	Хөрөнгийн албан татвар	245,764.10	331,229.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	427,093.80	528,686.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	26,604.60	63,273.00
1181	Газрын төлбөр	396,220.70	465,413.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,268.40	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	322,160.60	226,975.60
120	Нийтлэг татварын бус орлого	322,160.60	226,975.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,154,223.00	4,897,596.10
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,670,447.50	11,168,655.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,670,447.50	11,168,655.20

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,566,748.00	7,972,233.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,410,123.60	1,129,397.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,155.40	142,025.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,036,169.10	133,232.10
2104	Хангамж, бараа материалын зардал	39,933.70	29,756.30
2105	Нормативд зардал	810.3	1,226.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,482.60	2,814.50
2107	Томилолт, зочны зардал	2,455.40	5,617.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	741,714.10	5,987,378.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,903.70	540,784.90
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	82,184.40	76,666.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,021,515.00	3,119,755.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,428,191.60	5,217,430.40
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,912,695.70	2,810,432.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,912,695.70	2,810,432.70
2200	Дотоод эх үүсвэрээр	1,912,695.70	2,810,432.70
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,912,695.70	-2,810,432.70
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-416,610.80	-108,682.90
14	Бусад эх үүсвэр	0	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	416,610.80	108,682.90
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	98,885.10	2,298,314.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	405,578.70	504,463.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	504,463.80	2,802,778.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	62,235,563.20	62,235,563.20
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,339,067.20	21,339,067.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,899,791.90	61,899,791.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-335,771.20	-335,771.20
9	Тайлант үеийн үр дүн	-40,560,724.80	-40,560,724.80

11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	21,339,067.20	21,339,067.20
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	24,445,855.90	24,445,855.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,364,265.70	21,364,265.70
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	25,198.60	25,198.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-80.9	-80.9
19	Тайлант үеийн үр дүн	3,081,671.10	3,081,671.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан төгрөгөөр)

(мянган

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,352,993.30	8,317,656.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,034,305.90	5,855,963.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,888,673.90	5,713,664.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,146,888.60	1,129,397.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,360.90	142,025.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,254,475.00	3,213,518.11
2104	Хангамж, бараа материалын зардал	30,380.00	29,456.33
2105	Нормативд зардал	1,285.20	1,226.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	151,362.00	150,461.86
2107	Томилолт, зочны зардал	7,508.40	5,617.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	995,041.70	884,262.12
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,372.10	157,698.80
212	ТАТААС	80,000.00	76,666.66
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	80,000.00	76,666.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,632.00	65,632.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	65,632.00	65,632.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,866,924.20	2,353,010.71
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	451,763.20	108,682.87
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,352,993.30	8,548,759.98
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,716,222.40	8,341,234.53
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	636,770.90	207,525.45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	325,235.96
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	528,937.67
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	139	139
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	68	68

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан төгрөгөөр)

(мянган)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,738,602.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,291,604.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,268,992.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,676.92
2104	Хангамж, бараа материалын зардал	300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,865,929.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	383,086.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,612.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	300.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,312.09
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	446,998.00
2200	Дотоод эх үүсвэрээр	446,998.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,738,602.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,738,602.76
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 128,170.1 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 7,895.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт бичиж 120,274.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийтийн тээврийн үйлчилгээнд автобус худалдан авах гэрээг Мөнх цаст хаан ХХК-тай 2023 оны 06 сарын 16-ны өдрийн ХОАЖСЗДТГ/202301025 дугаартай гэрээ байгуулсан ч автобусаа хүлээлгэн өгөөгүй, гэрээ сунгаагүй байгаа нь худалдан авах гэрээний 6.3-д "Гүйцэтгэгч нь ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцроосон бол алданги тооцуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0.05 хувь, алдангийн нийт хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3.1.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Жаргалант ургамал ХХК ны гүйцэтгэсэн Буянт багийн өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэлийг зураг төсөвтэй тулган хянахад цонхны тавцанг зургийн дагуу чулуун тавцангаар хийгээгүй байгаа нь 2023 оны 09 сарын 09-ны өдрийн ХОАЖСЗДТГ/202207082 дугаарын Буянт баг өрхийн эрүүл мэндийн төв шинээр барих ажлын гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1-д "Гүйцэтгэгч нь ажлыг захиалагчийн өгсөн ажлын зураг, төсөв, даалгавар, тоо хэмжээ, техникийн нөхцөлийн дагуу гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.2 Зөвлөмж

3.2.1 Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрүүл жаргалант хөтөлбөр, Монгол гэр хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бодитой тодорхойлоогүйгээс үр дүнтэй хэрэгжүүлснийг үнэлэх боломжгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-д "Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бодитой тооцон сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах.

3.2.1 Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Он дамжсан өмнөх онуудын санхүүгийн тайланд бүртгэлтэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлагыг бууруулан ажиллах.

3.2.2 Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын ажлыг хүндэтгэн үзэх шалтгаангүй сунгасан байгаа нь 2022 оны 09 сарын 09-ны өдрийн ХОАЖСЗДТГ/202207082 дугаарын Буянт баг өрхийн эрүүл мэндийн төв шинээр барих ажлын гэрээний 2 дугаар зүйлийн 1-д "Буянт баг өрхийн эрүүл мэндийн төв шинээр барих ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдөр эхэлж, 2023 оны 07 дугаар сарын 30-ны өдөр хүлээлгэн өгнө", 4 дүгээр зүйлийн 4.1-д "Гүйцэтгэгч нь ажлыг захиалагчийн өгсөн ажлын зураг, төсөв, даалгавар, тоо хэмжээ, техникийн нөхцөлийн дагуу гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ" 6.3-д "Гүйцэтгэгч нь ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцроосон бол алданги тооцуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0.05 хувь, алдангийн нийт хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хувь байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын ажлын гэрээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сунгахгүй байх, гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллах

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			